



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/283

Булган сум

Салбар комисс шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.1 дэх заалтууд, Засгийн газрын 2021 оны Дүрэм шинэчлэн батлах тухай 173 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, маягт шинэчлэн батлах тухай” А/220, А/475, А/812 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын орон тооны бус салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Салбар комиссын дарга: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Б.Сарантуяа (Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эмч)  
Б.Мөнхтүвшин (Аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэдрэлийн эмч)  
Б.Алтантуяа (Боловсрол, шинжлэх ухааны газрын Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургах боловсрол хариуцсан ахлах арга зүйч)

Нарийн бичгийн дарга: Б.Лхаеийлхам (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч)  
У.Мөнгөнтуяа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, зорилтот бүлгийн хүн ам, өрхийн хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Салбар комиссын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж, хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутам холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллахыг Салбар комиссын дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/667 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010484